



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

"ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1, Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дүгээр заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.2, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г 2020 оноос эхлэн хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай. Үүнд:

а. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г сурталчлан таниулах ажлыг 2020 оны турш өргөн хүрээнд зохион байгуулж ажиллах, Үүнд:

- Стратеги төлөвлөгөөг нийтэд хүртээмжтэй хэлбэрээр орчин үеийн мэдээллийн бүхий л арга хэрэгслийг ашиглан сурталчлах;
- Их сургуулийн багш, оюутан, ажилтан, ажилчдад болон хамтран ажилладаг байгууллагуудад Стратеги төлөвлөгөөний үндсэн үзэл санааг ойлгуулах, таниулах ажлыг зохион байгуулах;

б. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхтэй холбогдсон санхүүгийн тооцоо, шаардагдах хөрөнгийн урьдчилсан хэрэгцээг 2020 оны 4 сарын 1-ны дотор гаргаж, удирдах зөвлөлд танилцуулах, жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс өмнө стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлын тооцоо, үндэслэлийг боловсруулж, улсын төсвийн төсөлд тусгуулах санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэх;

в. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан ШУТИС-ийн хэмжээнд мөрдэж байгаа дүрэм, журмуудыг шинэчлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Энэ хүрээнд:

- Дүрэм журмыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2020 оны 1 сарын 20-ны дотор байгуулж, ажлын үр дүнг 2020 оны 5 сарын 1-ны дотор Удирдах зөвлөлд танилцуулах;

- ii. Удирдах зөвлөлийн гишүүн Д.Баяр, Б.Дамдинсүрэн, Я.Төгөлдөр нарыг энэхүү ажлын хэсэгт Удирдах зөвлөлийн төлөөллөөр оруулж ажиллуулах;
- г. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан ШУТИС-ийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн талаар санал боловсруулах; Үүнд:
 - i. ШУТИС-ийн захиргааны бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх санал боловсруулах ажлын хэсгийг 2020 оны 1-р сарын 20-ны дотор байгуулж, ажиллуулах;
 - ii. Ажлын хэсгийн саналыг ШУТИС-ийн Захирлын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөр 2020 оны 2-р сард багтаан хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, улмаар удирдах зөвлөлийн хуралд танилцуулах;
 - iii. Ажлын хэсэгт ажиллах Удирдах зөвлөлийн төлөөлөлд Д.Болор, Д.Цолмонбаатар, Б.Сэргэлэн нарыг оролцуулах;
 - iv. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургууль, харья байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх талаар санал боловсруулах ажлыг 2020 оны 6-р сард багтаан зохион байгуулах;
- д. ШУТИС-ийн хэмжээнд ахисан түвшний сургалтыг зохион байгуулах ажлыг цоо шинэ шатанд гаргах талаар санал боловсруулах ажлын хэсгийг 2020 оны 1-р сарын 20-ны дотор байгуулж ажиллуулах, уг саналыг Удирдах зөвлөлд 3 сард багтаан танилцуулах.





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ШУТИС-ийн Музей байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.2, Дээд боловсролын тухай хуулийн 12.1.5, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7, ШУТИС-ийн Дүрмийн 3.3.2, Удирдах зөвлөлийн 2020 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн захиргааны бүтцэд “ШУТИС-ийн Музей”-т 2020 оны 01-р сарын 02-ны өдрөөс байгуулсугай.
2. Музейн үзмэрүүдийн бүртгэл хийж, 2020 оны 5 сард багтаан Удирдах зөвлөлд танилцуулахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д үүрэг болгосугай.
3. ШУТИС-ийн Музейг шинээр байгуулсантай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д үүрэг болгосугай.



367010005



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 03


Улаанбаатар хот

Найдваргүй авлагыг хүчингүй
болгох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дүгээр заалт, Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3 дугаар заалт, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.12-р, 4-54-р заалтууд, БСШУСЯ-ны Дотоод аудитын хорооны 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоол, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай холбогдох тогтолцоог зардлын $2,639,119,167 \div 56 = 46,708,102$ төгрөгийн найдваргүй авлагыг хүчингүй болгосугай.

2. Хүчингүй болсон найдваргүй авлагыг 2019 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар данснаас хасч, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэлд тусгах, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга /Д.Барсболд/ нарт даалгасугай.



367010009



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн орлогч
даргыг томилох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7 дахь заалт, БСШУС-ын Сайдын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/243 дугаар тушаал, ШУТИС-ийн дүрмийн 4.2, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 2.7, 2.8 дахь заалтууд, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үүсгэн байгуулагчийн санал болгосноор ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн орлогч даргаар Удирдах зөвлөлийн гишүүн, БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Г.Батнэмэхийг сонгосугай.



ДАРГА

Д.БАДАРЧ

367010011



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 27 өдөр


Дугаар 05

Улаанбаатар хот

Г Элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноо тогтоох тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 7.2 дахь хэсэг, БСШУС-ын Сайдын 2020 оны А/195 тоот тушаал, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд 2020-2021 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэхэд баримтлах Элсэлтийн Ерөнхий Шалгалтын босго оноог Улаанбаатар хотод 480 оноо, орон нутагт байрлах бүрэлдэхүүн, харьяа сургуулиудад 400 оноогоор тогтоосугай.
2. Элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад босго оноог баримтлан зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.



367010014



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Элсэлтийн хяналтын тоо батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 7.2 дахь хэсэг, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд 2020-2021 оны хичээлийн жилд элсүүлэх бакалавр оюутны элсэлтийн хяналтын тоог хавсралтаар баталсугай.
2. Хяналтын тоонд багтаан, элсэлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАДАРЧ

367010017



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 07.

Улаанбаатар хот

ШУТИС-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагааг дүгнэх тухай

Боловсролын тухай хуулийн 36.12.5 дугаар заалт, Үндэсний Аудитын Газрын 2020 оны 03 сарын 13-ны өдрийн 06-823 тоот Аудитийн гэрчилгээ, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.
2. 2020 онд төсөв, төлөвлөлтийн үйл ажиллагааны ажлын чанарт ахиц гарган, санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, үргүй зардлыг бууруулан, хэмнэлттэй ажиллахыг ШУТИС-ийн захирал Б.Очирбатад даалгасугай.
3. Үндэсний Аудитын Газрын албан шаардлагын биелэлтийг дурдсан хугацаанд хүргүүлж, зөрчлийг арилгах болон зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг ШУТИС-ийн Удирдах зөвлөлд танилцуулахыг ШУТИС-ийн захирал Б.Очирбатад даалгасугай.

ДАРГА

Д.БАДАРЧ



367010020



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Санхүүжилтийн зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.3 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дурмийн 3.1.5, Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвийн 2020 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 819/2020 тоот магадлалын нэгдсэн дүгнэлт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэл, 6 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ Нь:

- Хичээлийн 8 дугаар байрны барилгын нэмэлт ажлын зардал 224 500 000 /хоёр зуун хорин дөрвөн сая, таван зуун мянган/ төгрөгийг эрсдэлийн сан болон уг төслийн гүйцэтгэлийн хэмнэлтээс санхүүжүүлэхийг зөвшөөрсүгэй.
- Дээрх зардлыг ШУТИС-ийн 2020 оны үйл ажиллагааны төсвийн тодотголын саналд тусгахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/, ШУТИС-ийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Б.Сүхбат/ нарт даалгасугай.
- Гүйцэтгэгч "Монкон Констракшн" ХХК-тай хийх санхүүгийн тооцоог бүрэн барагдуулж, дуусгавар болгохыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал /Л.Баяр Эрдэнэ/ нарт даалгасугай.

ДАРГА

Д.БАДАРЧ



387010023



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.3 дугаар заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.4 дүгээр заалт, ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө, Удирдах зөвлөлийн 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зарим үйл ажиллагааг 2020 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг ШУТИС-ийн 2020 оны үйл ажиллагааны төсвийн тодотголын саналд тусгахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/, ШУТИС-ийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Б.Сүхбат/ нарт даалгасугай.

ДАРГА

Д.БАДАРЧ



367010026



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 10 өдөр


Дугаар 10

Улаанбаатар хот

ШУТИС-ийн 2020 оны төсвийн
тодотгол батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.3 дугаар заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.4 дүгээр заалт, Удирдах зөвлөлийн 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020 оны үйл ажиллагааны орлогын төсвийн тодотголыг нэгдүгээр, үйл ажиллагааны зарлагын төсвийн тодотголыг хоёрдугаар, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ШУТИС-ийн Захирал Б.Очирбат, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ нарт даалгасугай.



ДАРГА

Д.БАДАРЧ

367010029